



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/82

Цагаан-Уул сум

**Г Ой хээрийн түймрээс урьдчилан
сэргийлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5, 18.2.10, 18.2.12, 18.2.14, Шадар сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А/184 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хавар хуурайшилт ихсэж ой хээрийн түймэр гарах эрсдэл өндөр байгаа тул Багийн Засаг дарга, баг хариуцсан байгаль хамгаалагчдыг түймэрийн аюултай үеүүдэд хариуцсан багтаа түймэрийн эргүүл хийлгэх ажлыг зохион байгуулахыг сумын Гамшгаас хамгаалах штабын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай.

2. Багуудад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүл хийх хуваарийг нэгдүгээр хавсралтаар, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүл хийх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

4. Ой хээрийн түймрийн үед ажиллах 1, 2 дугаар ээлжийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг (Байгууллагын дарга эрхлэгч), (Багийн Засаг дарга) нарт тус тус даалгасугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж мэдээлэл, сурталчилгаа, удирдлага зохион байгуулалтаар шуурхай хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга, штабын дарга (Д.Түмэнбаяр)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ ДАРГА



У.АВАРЗЭД

/Zahiramj 2024/